



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

┌ Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 55.1.2-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам” /цаашид “журам” гэх/-ын 9.1-ийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

9.1. “Хамтын хөрөнгө оруулалтын сан нь энэхүү журмын 8.10-т заасан хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах өргөдлийг журмын хавсралт маягт СЗХ05003-ын дагуу гаргаж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2-т заасан баримт бичгээс гадна дараах бичиг баримтыг хавсаргана:” гэж.

2. Мөн журмын 2.7 дахь хэсэг, 7.1.3, 7.1.4 дэх заалтыг тус тус хүчингүйд тооцсугай.

3. Журамд холбогдох өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, Бүртгэл зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГЧ ҮЙЦЭНДЭГЧ
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

